



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчид бүртгэлгүй орхисон 186,178.55 (нэг зуун наян зургаан мянга нэг зуун далан найман төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид буюу "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА:


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

200698

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн
337 дугаар тогтоолын хавсралт



**"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн байршил	Хөрөнгийн нэр	Балансад бүртгэх өртөг (төгрөг)
1	Их тэнгэр цогцолбор 24 дүгээр байрын хажууд	ХТП-1196	186,178.55
			(нэг зуун наян зургаан мянга нэг зуун далан найман төгрөг тавин таван мөнгө)